




**“Идэвхтэй хөдөлгөөн - Эрүүл байхын үндэс, гэгээн өглөөг идэвхтэй  
хөдөлгөөн хийж угтъя” аяны хүрээнд зохион байгуулагдах  
“Мандалговь Марафон-1” бүх нийтийн гүйлтийн тайлан**

2019.06.03

2019 оны 6 дугаар сарын 1-ны өглөөний 7.30 цагаас аймгийн Чагдаржавын талбайгаас “Мандалговь-Марафон 2019” бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг Сайнцагаан сумын ЗДТГ, ЭМГазар, БТСГазар, Дундговь дахь Цагдаагийн газартай хамтран “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл байхын үндэс, гэгээн өглөөг идэвхтэй хөдөлгөөн хийж угтъя” аяны хүрээнд 3 насны ангиллаар зохион байгуулж нийт 400 тамирчид, төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, иргэд оролцсоноос: 46 дээш насны ангилалд эрэгтэй: Тэргүүн байранд Л.Нэргүй/ ГИЦСургууль/, дэд байранд Ч.Отгонбаяр, гутгаар байранд Б.Гантулга /ЭМГазар/, Эмэгтэй тэргүүн байранд Х.Эрдэнэчимэг / УЦУОШГазар/, дэд байранд Н.Эрдэнчимэг / ГИЦСургууль/, гутгаар байранд Ш.Хэрлэнбаяр, 36-45 насны ангилалд эрэгтэй тэргүүн байранд Б.Алтангэрэл / ГИЦС/, дэд байранд С.Угтахбаатар, гутгаар байранд Н.Энхтүвшин , Эмэгтэй: тэргүүн байранд Ш.Мөнх-Эрдэнэ, дэд байранд Д.Цэвэлмаа / Цагдаагийн газар/ , гутгаар байранд Б.Бямбасүрэн / Нэгдсэн эмнэлэг/, 18-35 насны ангилалд эрэгтэй : тэргүүн байранд Г.Цогтбаатар, дэд байранд П.Үүрцайх, гутгаар байранд Б.Ууганбат /Мандал сургууль/, эмэгтэй: тэргүүн байранд Ц.Цэрэнлхам / Нэгдсэн эмнэлэг/, дэд байранд О.Ням-эрдэнэ /ЭДЦС/, гутгаар байранд О.Буян-Орших /ЭДЦС/ нар шалгарч алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Байгууллага, хамт олноороо идэвх санаачлагатай оролцсон Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хүмүүнлэг сургуулийн хамт олонд Өргөмжлөл гардууллаа.

БАТЛАВ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Г. БАТ-ОРШИХ	БАТЛАВ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  М. НАРАНБАДРАХ	БАТЛАВ САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА  П. МӨНХТОГТОХ 2019 оны 05 сарын 21
--	---	---

**“Идэвхитэй хөдөлгөөн - Эрүүл байхын үндэс, гэгээн өглөөг идэвхитэй хөдөлгөөн хийж угтая” аяны хүрээнд зохион байгуулагдах “Мандалговь Марафон-1” бүх нийтийн гүйлтийн удирдамж**

**Зорилго:**

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдлыг ойлгуулан сурталчилах, эрүүл мэнд, бие бялдрын түвшинг сайжруулахад зорилго оршино.

**Ерөнхий ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллагууд:**

- БТСГазар
- ЭМГазар
- Сайнцагаан сумын ЗДТГазар

**Зохион байгуулалт:**

- Марафон гүйлтийн тэмцээнийг аймгийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Цагдаагийн газар хамтран 2019 оны 06 сарын 01-ний “Бямба” гаригт зохион байгуулж явуулна.
- Гүйлтэнд байгууллага, аж ахуй нэгжүүд ажиллагсдын 30 хувиас дээш бүрэлдэхүүнийг заавал оролцуулна.
- Ажилтан, албан хаагчдаа хамгийн их хамруулан зохион байгуулалттайгаар оролцуулсан 2 байгууллагыг шалгаруулан шагнаж урамшуулна.
- Марафон гүйлтийн зай, 46 дээш нас - 3 км, 36-45 нас - 5 км, 18-35 нас 6 км байх ба Г.Чагдаржавын талбайгаас гарч УЦУОШГазар – Авто тээврийн төв – Петровис ШТС – ТХДЖТ-ын уулзвар гэсэн маршрутаар явж Г.Чагдаржавын талбайд барианд орно.

**Шагнал урамшуулал:**

- Эрэгтэй, эмэгтэй тус бүр 18-35 хүртэл , 36-45 хүртэл , 46 дээш насны ангилалаар эхний 3 байр шалгаруулан өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль мөнгөн шагнал, 4-10-р байрт тусгай шагналаар шагнаж урамшуулна.
- Холбоо барих утас: 99598380

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС